

СЭРГЭЭН ЗАСАХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ 2025 ОНЫ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

Орхон аймаг

2025.12.30

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
Зорилго: Сэргээн засах, тусламж үйлчилгээг урт болон богино хугацаагаар, нотолгоонд суурилсан цогц байдлаар үзүүлэх, чанартай аюулгүй, үйлчлүүлэгч төвтэй тусламж, үйлчилгээний зарчмыг баримтлах замаар олон улсын жишигт нийцүүлэн сайжруулж, хөгжүүлэх					
НЭГ. ХУУЛЬ ТОГТООМЖ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ					
1.	Сэргээн засах тусламж үйлчилгээнд мөрдөгдөж хууль эрх зүйг сурталчлах, хэрэгжилтэд хяналт тавих, арга зүйгээр хангах	1	2	Эрүүл мэндийн байгууллагуудад хэрэгжиж буй хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ЭМС-ын тушаал, заавар, хууль эрхзүйн баримт бичгийн товъёог боловсруулж салбаруудад хүргүүлсэн. Сэргээн засах тусламж үйлчилгээг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, салбаруудад хүргүүлэн, хэрэгжилтийн ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/502, 2021 оны А/749 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд аймгийн хэмжээнд сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлж буй БОЭТ, Эрдэнэт сувиллын цогцолбор, хувийн хэвшлийн ортой эмнэлгүүд, сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүдэд 5 шалгуур үзүүлэлтийн дагуу явцын хяналт хийж, нийт дундаж үнэлгээ 87.8 хувьтай үнэлэгдсэн.	100
2.	Сэргээн засах тусламж үйлчилгээг анхан шатлалд бэхжүүлэх, шатлал хоорондын хамтын ажиллагааг сайжруулах ажлыг зохион байгуулах	1	Шатлал хооронд туршлага судлах үйл ажиллагаа зохион байгуулагдсан байна.	УИХ-ын гишүүн, нийгмийн эрүүл мэндийн ухааны доктор О.Саранчулууны санаачилгаар Ерөнхий сайд Г.Занданшатарын ивээл дор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, Бие бялдар сэргээн засах судлалын Монголын нийгэмлэг, "Тэгш нийгэм холбоо" ТББ хамтран "Сэргээн засалт ба хөгжлийн бэрхшээл" үндэсний чуулганд БОЭТ-ийн сэргээн засах тасгийн эрхлэгч, ЭСЦ-ын сэргээн засах тасгийн их эмч нарын бүрэлдэхүүнтэй нийт 4 эмч, мэргэжилтнүүд хамрагдаж мэдээлэл авсан. Эрдэнэт сувиллын цогцолбортой хамтран орон нутагтаа "Сэргээн засалт ба хөгжлийн бэрхшээл" өдөрлөгийг зохион байгуулан ажилласан. Тус өдөрлөгөөр сэргээн засахын тусламж үйлчилгээ үзүүлж буй Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Тайхар эмнэлэг, очир увидас	80

				эмнэлэг, Жаргалант сумын эрүүл мэндийн төв, бусад 8 өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 25 эмч, эмнэлгийн мэргэжилтэнгүүд эрдэнэт сувиллын цогцолборын сэргээн засах тасгийн үйл ажиллагаатай танилцаж туршлага судалсан.	
3.	Сэргээн засахын тусламж үйлчилгээг үзүүлж буй эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах	-	Сэргээн засахын эмч, эмнэлгийн мэргэжилтэнг сургалтад хамруулсан байна.	Аймгийн хэмжээнд Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт сувиллын цогцолборт сэргээн засахын их эмч 6 хөдөлгөөн засалч 4 хөдөлмөр засалч 2 Сум өрхийн эрүүл мэндийн төвүүдэд сэргээн засахын сувилахуйн мэргэжилтэн тус бүр нэг ажиллаж байна. ЭМС-ын 2021 оны А/749 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд “Сэргээн засалт ба хөгжлийн бэрхшээл” өдөрлөг - 1, танхимын сургалт 2 удаа зохион байгуулж 21 эрүүл мэндийн байгууллагын байгууллагын давхардсан тоогоор 55 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулсан. - АШУҮИС-ын Анагаахын сургуулийн сэргээн засах анагаах ухааны тэнхимтэй хамтран “Мэдрэл булчингын хэт авиан оношилгоо, эмчилгээ” сэдвийн хүрээнд 12 эрүүл мэндийн байгууллагын 25 эмч хамрагдсанаар хэт авиан шинжилгээг сэргээн засах оношилгоо, эмчилгээнд хэрэглэх арга, булчин чангаралтын менежмент, ботулин токсин А талаарх мэдлэг сайжирсан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдэд “Хүүхдийн хөгжлийн онцлог, аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийг хөгжүүлэх арга зүй” “Хөдөлмөр засал, зөв байрлал, хооллолт” “Булчин чангарлын менежмент” зэрэг сэдвүүдийн хүрээнд сургалтуудыг зохион байгуулж 35 эцэг эх, асран хамгаалагч нар оролцож мэдлэгээ нэмэгдүүлсэн. - Асах гэрэл баясал Төрийн бус байгууллагатай хамтран “Аутизмыг илрүүлэхэд бидний оролцоо” сэдэвт сургалтыг СӨЭМТ-үүдийн сэргээн засахын сувилахуйн 9 мэргэжилтнүүдийг хамруулсан 2 өдрийн сургалтыг зохион байгуулсан. Энэхүү сургалтаар аутизмын тухай ойлголт нэмэгдэж, аутизмыг эрт илрүүлэх, ирээдүйд гарах олон сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх мэдлэгийг нэмэгдүүлсэн.	100
4.	Сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагуудад ICF олон улсын ангиллыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх	-	ICF олон улсын ангиллыг тусламж үйлчилгээнд	“Сэргээн засалт ба хөгжлийн бэрхшээл” үндэсний чуулганд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн сэргээн засахын тасгийн эрхлэгч, Эрдэнэт сувиллын цогцолборын сэргээн засахын их эмч нар хамрагдсанаар Үйл ажиллагаа, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээл, ICF-ийн олон улсын ангилалд суурилсан тусламж,	80

			нэвтрүүлсэн эрүүл мэндийн байгууллагы удын тоо нэмэгдсэн байна	эмчилгээ, Тархины саатай хүүхдийн үйл ажиллагааны ICF-CY үнэлгээ ба булчин чангарлын сэргээн засах цогц менежментын талаарх мэдлэг дээшилснээр ICF үнэлгээг шаардлагатай 128 үйлчлүүлэгчидэд эмчилгээний үр дүнг тооцох зорилгоор ашигласан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн толгой даах, эргэж хөрвөөх, бие даан суух, мөлхөх, зогсох, алхах хөдөлгөөний чадвар алдалтыг үнэлэх зорилгоор GMFM-88 үнэлгээг хийж байна.	
ХОЁР. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ					
5.	Сэргээн засах тусламж, үйлчилгээний хүртээмжийг үнэлж, нэр төрлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого зохицуулалтаар ханган, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллах	7	Тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдсэн байна.	Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/502 дугаар тушаал, 2021 оны А/749 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд аймгийн хэмжээнд сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудад явцын хяналтыг зохион байгуулан ажиллалаа. Явцын хяналтад Бүсийн оношилгоо эмчилгээний төв (БОЭТ), Эрдэнэт сувиллын цогцолбор, хувийн хэвшлийн ортой эмнэлгүүд, сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүд хамрагдсан бөгөөд нийт 5 шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийсэн. Хяналтын үр дүнг шалгуур тус бүрээр дараах байдлаар үнэлэв. Үүнд: • Хүний нөөцийн хангалт – 85% • Тоног төхөөрөмжийн хангалт – 89% • Нэг удаагийн хэрэгсэл, хэрэглэгдэхүүний хангалт – 91% • 2025 оны сэргээн засах тусламж үйлчилгээг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт – 88.3% • Анхан шатны маягт бүрдүүлэлт – 86% Дээрх шалгуур үзүүлэлтүүдийн нийт дундаж үнэлгээ 87.8%-тай гарсан бөгөөд илэрсэн зөрчил, сайжруулах шаардлагатай асуудлуудад үндэслэн зөвлөмжийг нэгтгэн холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн болно. Сэргээн засах тусламж, үйлчилгээний чанар, үр дүнг сайжруулах зорилгоор зарим эрүүл мэндийн байгууллагуудад тоног төхөөрөмжийн шинэчлэл, нэмэгдэл хийгдсэн байна. Үүнд: • БОЭТ-ийн сэргээн засах эмчилгээний тасагт Солонгос улсын <i>Seragem V4</i> массажны орыг нурууны суулттай үйлчлүүлэгчдэд нурууны татлага хийх эмчилгээнд нэвтрүүлэн ашиглаж эхэлсэн. • Сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүдэд витрон шарлагын аппарат, чихний лаа, парафин, улаан гэрлийн аппарат зэргийг шинээр нэмж, анхан шатны сэргээн засах тусламжийн боломжийг өргөжүүлсэн.	100

				• Эрдэнэт Медикал төрөлжсөн эмнэлэг нь өвдөгний үеийн хагалгааны дараах болон гэмтлийн дараах хөдөлгөөн засалд зориулсан аппаратыг шинээр нэвтрүүлсэн. • Баян-Өндөр эмнэлэг сэргээн засах тусламжид ашиглах <i>ICT-Tense</i> аппаратыг нэмэгдүүлсэн. • Тайхар эмнэлэг 2025 онд сэргээн засах эмчилгээний тасгийг шинээр байгуулснаар тусламж үйлчилгээний нэр төрөл өмнөх онтой харьцуулахад 15 хувиар нэмэгдсэн байна.	
6.	Мэргэжлээс шалтгаалах өвчний кабинетын хяналтад буй үйлчлүүлэгчийг сэргээн засах тусламж үйлчилгээнд тогтмол хамрагдаж байгаа эсэхийг үнэлэх, зөвлөмж өгч ажиллах	200	Сэргээн засах тусламж үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо нэмэгдсэн байна.	Аймгийн хэмжээнд мэргэжлээс шалтгаалах өвчний кабинет нь Эрдэнэт сувиллын цогцолборт байршиж, иргэдэд мэргэжлээс шалтгаалах өвчний оношилгоо, хяналт, сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Тус кабинет нь хүний нөөцийн хувьд 2 их эмч, 1 сувилагчийн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж, мэргэжлээс шалтгаалах өвчний урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэлт, хяналт, зөвлөгөө мэдээлэл олгох чиглэлээр ажилласан болно. Тайлант хугацаанд нийт 326 иргэн кабинетийн хяналтад хамрагдсан байна. Үүнээс 202 иргэн сэргээн засах тусламж, үйлчилгээ авсан бөгөөд үлдсэн иргэдэд оношилгоо, хяналтын үзлэг, мэргэжлийн зөвлөгөө, зааварчилгаа өгч ажиллалаа. Сэргээн засах тусламж, үйлчилгээ нь иргэдийн хөдөлмөрийн чадварыг хадгалах, өвчний хүндрэлээс сэргийлэх, амьдралын чанарыг сайжруулахад чиглэсэн бөгөөд эмчийн заалт, хяналтын дагуу үе шаттайгаар хэрэгжүүлсэн болно.	100
7.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисст шинээр нэмэгдсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сэргээн засах тусламж үйлчилгээнд хамруулах, үр дүнг тооцох	90	Сэргээн засах тусламж үйлчилгээнд хамруулах	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн мэдээллийн санг бүрдүүлж, бусдын адил эрхээ эдлэх, нийгэм дэх оролцоог нэмэгдүүлж, тэдний боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах зорилгоор аймгийн Засаг даргын 2025 оны А/347 дугаар захирамжийн дагуу "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс" байгуулагдан үйл ажиллагаа нь тогтмолжсон. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс тайлант хугацаанд 21 удаа хуралдаж нийт 391 хүүхдэд комиссын хурлаар орсон байна. Үүнээс эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд 168, боловсролд 55, сунгалт 89, цуцлагдсан 38, шинээр орсон 69, буцаагдсан 28, бусад 112 хүүхдийн асуудлыг шийдвэрлэсэн байна. Тайлант	100

				хугацаанд нийт 126 хүүхдийг сэргээн засах тусламж үйлчилгээнд хамруулсан байна.	
8.	Хүүхдийн сувилал, ЭМБ-уудын сэргээн засах тусламж үйлчилгээнд дэмжлэгт хяналт хийж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах	2	Хүүхдийн сувилал, сэргээн засах тусламж, үйлчилгээнд хяналт хийж, зөвлөмж өгсөн байна.	Тайлант хугацаанд зорилтот бүлгийн суурь өвчтэй сульдаа, цус багадалт, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нар, ус, агаар, эмчилгээний хоол, сүү цагаан идээ, аминдэмжүүлэлтэнд хамруулан эрүүлжүүлэн чийрэгжүүлэх үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс 30,0 сая төгрөгийг шийдвэрлэсэн. Суурь өвчтэй хүүхдүүдийг чийрэгжүүлэхбэлтгэл ажлын хүрээнд 5 хүртэл насны суурь өвчтэй хүүхдийн судалгааг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс авч нэгтгэн 272 хүүхдийн судалгааг гаргасан байна. Суурь өвчтэй хүүхдүүдийг чийрэгжүүлэх, гэр сувиллыг гэрээгээр гүйцэтгүүлэхээр сонгон шалгаруулалт зарлагдаж, сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсэгт ажиллаж хүүхдийн сувилалд хийсэн үнэлгээний дүгнэлтийг гаргаж хүргүүлсэн. Тус сонгон шалгаруулалтад Бүжинлхам хүүхдийн чийрэгжүүлэх гэр сувилалд 0-5 хүртэх насны суурь өвчтэй сульдаа, цус багадалт, хөгжлийн бэрхшээлтэй 100 хүүхдийг нар, ус, агаараар чийрэгжүүлсэн. Сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлж буй 14 эрүүл мэндийн байгууллагуудад дэмжлэгт хяналтыг хийхэд 87.8%-тай үнэлэгдсэн.	90
9.	Олон улсын болон төрийн бус байгууллагуудтай хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сэргээн засахын нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах	45	50	Эрхэм нандин сувд ТББ-тай хамтран 2 дахь жилдээ “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг лавлагаа шатлалын нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах үзлэг”-ийг зохион байгуулан ажилласан. Аутизм, тархины саа саажилт, уналт таталт, эпипси, тархины усжилттай хөгжлийн бэрхшээлтэй 33 хүүхэд үзлэгт хамруулсан. Тус үзлэгээр Гэмтэл согог судлалын үндэсний төвийн хүүхдийн гэмтлийн мэс заслын эмч, ШУГТЭ-ийн зүрхний мэс заслын эмч, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн сэтгэцийн 2 эмч, Эх нялхсын эрүүл мэндийн төвийн чих хамар хоолойн, сэргээн засах, дотор, нүд, уушги, бөөр, мэдрэл, үе мөч, зүрх судас, дотоод шүүрэл, хоол боловсруулах эмгэг зэрэг хүүхдийн нарийн мэргэжлийн 19 эмч нар үзлэгийг явуулж давхардсан тоогоор 172 нэр төрлийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамрагдсан байна. Монголиан Азиа Рийч байгууллагын дэргэдэх Гэрэл-Өөд хөгжлийн төвтэй хамтран тархины саа саажилт, хөдөлгөөн хөгжлийн хоцрогдолтой хүүхдүүдэд Солонгон ертөнц клиникт 2	100

				дахь жилдээ үзлэг зохион байгуулсан. Гэрэл-Өөд хөгжлийн төвийн хүүхдийн мэдрэлийн эмч болон хөдөлгөөн засалч нар хөгжлийн бэрхшээлтэй нийт 49 хүүхдэд үзлэг хийгдсэн.	
10.	Сум,өрхийн эрүүл мэндийн төвүүдийн сэргээн засах тусламж үйлчилгээнд ашиглагдаж байгаа багаж тоног төхөөрөмж, туслах хэрэгслийн тоог нэмэгдүүлэх	-	Тоног төхөөрөмж, туслах хэрэгслийн тоо нэмэгдсэн байна	Тайлант хугацаанд Сум,өрхийн эрүүл мэндийн төвүүдэд давхардсан тоогоор 7972 иргэнд сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. Сум өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц үйл ажиллагаа 5292:2017 стандартын дагуу 90%-д сэргээн засахын тоног төхөөрөмжийг ашиглаж байна.	90
ГУРАВ. ОЛОН НИЙТ, ХАМТ ОЛОНД ТҮШИГЛЭН СЭРГЭЭН ЗАСАХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ					
11.	Олон нийтэд хүрч буй эрүүл мэндийн боловсрол олгох хөтөлбөрт сэргээн засах тусламж,үйлчилгээний тухай тогтмол оруулж мэдээллэх	1	Олон нийтэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулагдсан байна.	Олон нийтэд хүрч буй эрүүл мэндийн боловсрол олгох хөтөлбөрийн хүрээнд сэргээн засах тусламж, үйлчилгээний талаарх мэдлэг, мэдээллийг иргэдэд тогтмол хүргэх, зорилтот бүлгийг дэмжих, анхан шатны түвшний сэргээн засах тусламжийг хөгжүүлэх чиглэлээр тасралтгүй ажилласан. “Сэргээн засалт ба хөгжлийн бэрхшээл” сэдэвт өдөрлөгийг зохион байгуулж, 15 хүүхдэд сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэн, тэдний эцэг эх, асран хамгаалагчдад гэрийн нөхцөлд хийх дасгал, аргуудын талаар заавар зөвлөгөө өгч, сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн эмч нарт анхан шатны түвшинд сэргээн засах тусламжийг хөгжүүлэхэд чиглэсэн мэргэжлийн зөвлөмж мэдээлэл хүргүүлсэн. Мөн мэргэжлийн өдрүүдийг тохиолдуулан иргэдэд чиглэсэн эрүүл мэндийн боловсрол олгох арга хэмжээг зохион байгуулсан. 10 дугаар сарын 27-ны Хөдөлмөр заслын өдрийг тохиолдуулан өдөрлөг зохион байгуулж, нийт 48 хүнд хөдөлмөр заслын эмчилгээний ач холбогдол, хэрэглээний талаар зөвлөгөө, зөвлөмж өгсөн бол 9 дүгээр сарын 8-ны Хөдөлгөөн заслын өдрийг тохиолдуулан зохион байгуулсан өдөрлөгөөр 54 үйлчлүүлэгчид хөдөлгөөн заслын эмчилгээ, дасгал хөдөлгөөний ач холбогдлын талаар мэдээлэл хүргэсэн. Үүний зэрэгцээ зорилтот бүлгийн 10 үйлчлүүлэгчид гэрээр очиж, тархины харвалтын дараах сэргээн засах дасгал хөдөлгөөнийг зааж сурган, сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэн гарын бэлэг гардуулсан байна.Тайлант хугацаанд сэргээн засах тусламж, үйлчилгээтэй холбоотой эрүүл мэндийн	100

				боловсролыг нийт 2,570 үйлчлүүлэгчид 45 сэдвээр олгож, иргэдийн өвчнөөс урьдчилан сэргийлэх, сэргээн засах арга хэмжээнд идэвхтэй оролцох мэдлэг, хандлагыг нэмэгдүүлсэн. Мөн байгууллагын албан ёсны веб сайт болон цахим хуудсуудаар дамжуулан иргэдэд чиглэсэн сэргээн засахын төрөлжсөн тусламж, үйлчилгээний талаар 41 мэдээлэл, 4 видео материалыг тогтмол байршуулсан бөгөөд эдгээр нь нийт 12,711 хандалт авч, 181 удаа хуваалцагдаж, 310 “лайк” авсан нь олон нийтэд хүрч буй эрүүл мэндийн боловсролын хүртээмж, үр нөлөө сайжирсныг илтгэж байна.	
12.	Сэргээн засах тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэдийг дэмжих, урьдчилан сэргийлэх, хамгаалах боломжийг ЭМБ-уудад бүрдүүлэх	-	Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байна.	ХГБХХГ, БГ-тай хамтран 4 өдрийн сургалтыг зохион байгуулж “Бага насны хүүхдийн хөгжлийн онцлог, эрх хамгаалал, эрүүл мэнд, хоол тэжээл, анхан шатны тусламж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн” талаар мэдлэг олгосоноор "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Найдвар" ТББ болон Онцгой байдлын дэргэдэх хүүхэд харах төвийн 5 ажилтан хүүхэдтэй ажиллах мэдлэг, чадвар, зөв хандлагатай мэргэшсэн хүүхэд харагч болж бэлтгэгдсэн. 2025 оноос эхлэн АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэстэй хамтран “Солонгон ертөнц” сэргээн засах клиник дэмжлэгт төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү төсөл нь 17 сая төгрөгийн санхүүжилттэйгээр хэрэгжиж, СӨБ-ын 27 болон 7 дугаар цэцэрлэгийн тархины саа, саажилт, эпилепси гэсэн оноштой 15 хүүхдэд 3 сарын хугацаанд урт хугацааны сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлсэн. Төслийн хүрээнд нийт 1920 удаагийн сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Мөн БОЭТ-ийн Сэргээн засах эмчилгээний тасагт 45 хүүхэд хамрагдаж, нийт 225 удаагийн богино хугацааны сэргээн засах тусламж үйлчилгээнд хамрагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрүүл мэндийн болон нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлдэг, тэдний хөгжлийг дэмжих чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудад АЗДТГ-аас 242 сая төгрөгийг шийдвэрлэж үйл ажиллагааг дэмжин ажилласанаар 157 иргэн өөрт шаардлагатай үйлчилгээнд хамрагдаж эрүүл мэнд, нийгмийн оролцоо бие даан амьдрах чадвар 18%-аар нэмэгдсэн. Тайлант хугацаанд БОЭТ-ийн сэргээн засах эмчилгээний тасаг 8975 хүнд, Эрдэнэт сувиллын цогцолборын амбулатори 2757 , стационарит 987 ,Сум,өрхийн	100

				эрүүл мэндийн төвүүдэд давхардсан тоогоор 7972, Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд 24630 хүнд сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.Аймгийн хэмжээнд тусламж үйлчилгээ шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй 3897 иргэнд 19485 удаагийн урт болон богино хугацааны сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. “Хөгжлийн бэрхшээлтэй, хэвтрийн болон ахмад настуудыг үзлэг, оношилгоо, сэргээн засах дасгал хөдөлгөөн эмчилгээнд хамруулах”, “Ахмадын сэргээн засах засах тусламж үйлчилгээг дэмжих” удирдамжтай ажлыг зохион байгуулж сэргээн засах тусламж үйлчилгээг нэмэгдүүлсэнээр үйл ажиллагааны хэргэжилт 98%-тай байна.	
Үнэлгээний хувь 95,0%/Тодорхой үр дүнд хүрсэн/					

ТАЙЛАН ГАРГАСАН: УАУСЗТҮХБИАХМЭРГЭЖИЛТЭН

М.БЯМБАСҮРЭН

ХЯНАСАН: ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

П.ХИШГЭЭ

СЭРГЭЭН ЗАСАХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ 2025 ОНЫ АРГА ХЭМЖЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин /2020/	Хүрэх түвшин /2025/	Хүрсэн түвшин Орхон /2025 он/	Тайлбар
Үр нөлөөний болон үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд						
1	Сэргээн засах цогц тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагын тоо	тоо	1	2	3	Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт сувиллын цогцолбор, Тайхар эмнэлэгүүдэд сэргээн засахын тусламж үйлчилгээг үзүүлж байна.
2	Хөдөлгөөн засалч	тоо	134	4	4	Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 1, Эрдэнэт сувиллын цогцолбор 3

	Хөдөлмөр засалч		тоо	14	2	2	Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 1, Эрдэнэт сувиллын цогцолбот 1
	Сэргээн засахын их эмч		тоо	161	5	5	Эрдэнэт сувиллын цогцолбор 4, Тайхар эмнэлэгт 1 сэргээн засахын их эмч ажиллаж байна.
	Сэтгэл зүйч		тоо	8	4	4	Медикал, эмг, мэндцэцн мөнхийн гэгээ уяралтбаяр
	Сэргээн засахын сувилагч		тоо	384	15	15	Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 8, Эрдэнэт сувиллын цогцолбор 3, эрдэнэт медикал 2, хувийн хэвшлийн ортой эмнэлгүүдэд 2
	Бусад засалч		тоо	47	8	8	Хувийн хэвшлийн ортой эмнэлгүүдэд 6, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 1, Эрдэнэт сувиллын цогцолбор 1
3	Тухайн онд сэргээн засах тусламж үйлчилгээний чиглэлээр үндсэн мэргэжлээр сургалтад хамрагдсан хүний тоо		тоо	-	1	1	Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөс сэргээн засахын их эмчээр суралцаж байна.
4	Uptodate олон улсын эмнэлзүйн удирдамжийн цахим платформыг хэрэглэж хэвшсэн байгууллага		тоо	-	10	11	Нийт 11 эрүүл мэндийн байгууллага Uptodate олон эмнэлзүйн удирдамжийн цахим платформыг хэрэглэж байна.
5	Хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгчдийн тоо		тоо	73276	3166	3166	-
6	Шинээр хяналтад орсон хөгжлийн жирэмсэн эмэгтэйчүүдийн тоо		тоо	581	6	5	Шинээр хяналтад орсон хөгжлийн жирэмсэн эмэгтэйчүүдийн тоо өмнөх оны мөн үеэс 1-ээр буурсан байна.
7	Сэргээн засах тасагт эмчлүүлсэн хүний тоо		тоо	991	950	987	Эрдэнэт сувиллын цогцолборын сэргээн засах эмчилгээний тасагт 987 иргэн хэвтэн эмчлүүлсэн байна.
8	Сэтгэл засал эмчилгээнд хамрагдсан хүний тоо		тоо	14422	1850	1960	Сэтгэл засалч эмчээс 1960 хүн үйлчилгээ авч, идэвхтэй хяналтанд байсан 42, эдгэрсэн 35 үйлчлүүлэгч байна
10	Сэргээн засах эмчилгээ хийлгэсэн хүн /10 000 хүн амд/	Амбулатори	/10 000 хүн амд/	2193	1500	1852	Сэргээн засах эмчилгээ тусламж үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 2,1%-иар буурсан байна.